



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 07 өдөр

Дугаар A/564

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Хөөмийг Геннисийн амжилтанд бүртгүүлэхээр ажиллаж буй хөөмийч, багш Н.Хосбаярын байр хоолны зардалд 734 600 төгрөг, аймгийн урилгаар Хөгжим бүжгийн коллежид элсэлт авч ажилласан Б.Ширчинбаатарын байр хоолны зардалд 654 700 төгрөг, Аудитын ерөнхий газрын газрын төлөөлөл манай аймагт ажилласан байрны зардалд 520 000 төгрөг, Орхон аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг манай аймагт ажилласан зардалд 416 000 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2.Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 2 325 300 төгрөг /Хоёр сая гурван зуун хорин таван мянга гурван зуун/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д, үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ